

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/037/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@gmail.com
	Б энд С аудит ХХК-ийн Захирал Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: info@bcauditllc.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54

И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14

№

01/308

танай _____-ны № _____-т

“БАГАХАНГАЙ ТОХИЖИЛТ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ГЭРЭЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дүүргийн Засаг даргатай байгууллагын дарга онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулж ажиллаагүй байна.

Багахангай дүүргийн тамгын газраас онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах нь оны эцэст ажил дүгнэх, гүйцэтгэлийг үнэлэхэд хүндрэлтэй байгаа тул хог хаягдлын үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээ гэж байгуулахаар мэдэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны А/10 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн батлагдсантай

холбогдуулан, байгууллагын захирал, ажилчдын цалинд нэмэлт өөрчлөлт оруулж мөрдөн ажиллаж байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 100 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	31,480,763.18	108,922,905.19
1.1.2	Дансны авлага	7,200.00	864,000.00
1.1.4	Бусад авлага	161,703.30	670,924.74
1.1.6	Бараа материал	65,630,896.73	136,314,085.15
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	274,967.83	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,555,531.04	246,771,915.08
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,018,254,796.52	1,148,425,671.81
1.2.2	Биет бус хөрөнгө	124,042,800.00	123,250,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,142,297,596.52	1,271,676,471.81
1.3	Нийт хөрөнгийн дүн	1,239,853,127.56	1,518,448,386.89
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	2,054,380.00	
2.1.1.3	Татварын өр	1,815,558.41	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,869,938.41	
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,869,938.41	
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч		
2.3.1	-төрийн	2,335,891,977.11	2,747,824,907.63
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	298,893,948.67	298,893,948.67
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	116,944,800.00	116,944,800.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,515,747,536.63)	(1,645,215,269.41)
	Тайлангийн үеийн ашиг		(129,467,732.78)
	Өмнөх үеийн ашиг	(1,515,747,536.63)	(1,515,747,536.63)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,235,983,189.15	1,518,448,386.89
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,239,853,127.56	1,518,448,386.89

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	746,026,272.72	1,478,703,924.36
2	Борлуулалтын өртөг	654,760,733.81	1,210,414,019.43
3	Нийт ашиг (алдагдал)	91,265,538.91	268,289,904.93
10	Ерөнхий ба удирдлагын зардал	265,930,229.10	357,773,104.96
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	28,224,308.78	39,984,532.75
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(202,888,998.97)	(129,467,732.78)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	(202,888,998.97)	(129,467,732.78)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(202,888,998.97)	(129,467,732.78)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(202,888,998.97)	(129,467,732.78)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,343,274,834.51	298,893,948.67	116,944,800.00	(1,312,216,820)	1,446,896,763
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(202,888,999)	(202,888,999)
3	Өмчид гарсан өөрчлөлт	(7,382,857.40)				(7,382,857.40)
4	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,335,891,977.11	298,893,948.67	116,944,800.00	(1,515,747,537)	1,235,983,189
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
6	Залруулсан үлдэгдэл					
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(129,467,732.78)	(129,467,732.78)
9	Өмчид гарсан өөрчлөлт	411,832,930.52				411,832,930.52
10	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,747,824,907.63	298,893,948.67	116,944,800.00	(1,645,215,269.41)	1,518,448,386.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	821,318,485.65	1,623,780,166.32
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	42,814,500.00	2,696,800.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,402,381.00	524,468.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	715,027,747.01	1,180,033,951.88
1.1.6	Бусад мөнгөн орлого	61,073,857.64	440,524,946.44
1.2	Мөнгөн зарлагын дүн	798,168,960.44	1,521,908,024.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	363,146,239.13	768,626,216.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	102,661,078.09	225,596,279.70
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	111,016,192.50	143,298,605.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	64,634,833.09	59,624,601.12
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	51,169,200.00	48,729,214.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	92,516,862.63	227,906,994.83
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,206,135.00	7,958,070.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	11,818,420.00	40,168,043.44
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	23,149,525.21	101,872,142.01
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-
2.1	Мөнгөн орлогын дүн		-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн	46,050,000.00	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	46,050,000.00	24,430,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(46,050,000.00)	24,430,000.00
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн		24,430,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн		-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(22,900,474.79)	77,442,142.01
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	54,381,237.97	31,480,763.18
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	31,480,763.18	108,922,905.19

Багахангай Тохижилт ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил байхгүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар нийт 1,464.5 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүлсэн.

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэж буй үйлчилгээний автомашинтай боловч албан хаагчдын хувийн автомашинд 1,464.5 мянган төгрөгийн шатахуун олгосон	1	1,464.5	1	1,464.5						
Онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө батлуулаагүй байна.	1	-					1	-		
Дүн	2	1,464.5	1	1,464.5						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.